



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
РЕКТОРЫН ТУШААЛ

2025 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/596

Улаанбаатар хот

МУИС-д хичээл дүйцүүлэх журмыг
шинэчлэн батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалт, Дээд боловсролын тухай хуулийн 11.3, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/216 дугаар тушаалаар баталсан "Дээд боловсролын сургалтын агуулгыг багц цагаар тооцох, багц цагийг дүйцүүлэх журам", МУИС-ийн Дүрмийн 5.4.1, 5.4.8.9 дэх хэсэг, МУИС-ийн ректорын зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн хурлын тэмдэглэл, шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "МУИС-д хичээл дүйцүүлэх журам"-ыг хавсралтаар шинэчлэн баталж, 2025-2026 оны хичээлийн жилээс эхлэн мөрдсүгэй.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан МУИС-ийн захирал (ректор)-ын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/361 тоот тушаалаар батлагдсан "МУИС-д хичээл дүйцүүлэх журам"-ыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэхүү журмыг холбогдох нэгжүүдэд сурталчлан, хэрэгжүүлж ажиллахыг Сургалт, хөтөлбөр чанарын баталгаажуулалтын газрын дарга (С.Булгантамир), бүрэлдэхүүн болон салбар сургуулийн захирлууд (Б.Болд-Эрдэнэ, С.Мөнхбат, Ц.Амартайван, Н.Батнасан, Б.Амарсанаа, Ч.Сономдавга, Б.Ганбат, Ц.Пүрэвсүрэн, Д.Алтанхуяг, Б.Мядагмаа) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Журмын хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж ажиллахыг Сургалт, оюутны хөгжил эрхэлсэн проректор (Д.Заяабаатар)-д үүрэг болгосугай.


РЕКТОР



Б.ОЧИРХУЯГ

1425095363

Монгол Улсын Их Сургуулийн
Ректорын 2025 оны /дугаар сарын /-ны
өдрийн /596/ дугаар тушаалын хавсралт



МУИС-Д ХИЧЭЭЛ ДҮЙЦҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Суралцагчийн өмнө нь судалсан мэдлэг, чадвар, хандлага, төлөвшлийг хүлээн зөвшөөрөх нөхцөлийг тодорхойлоход энэхүү журмын зорилго оршино.

1.2. Суралцагчийн өмнө нь амжилттай судалсан, тодорхой түвшний суралцахуйн үр дүнг эзэмшсэн хичээл, түүнтэй адилтгах сургалт (цаашид “хичээл” гэнэ), түүний үнэлгээг МУИС-д хэрэгжиж буй хичээлийн агуулга, багц цаг, үнэлгээтэй дүйцүүлэн тооцоход холбогдох харилцааг зохицуулахад энэхүү журмыг (цаашид “журам” гэнэ) мөрдөнө.

1.3. МУИС-ийн боловсролын ижил түвшний хөтөлбөрт шилжин суралцах, өмнө нь дээд (дипломын болон бакалавр, магистрын) боловсрол эзэмшсэн төгсөгч эсвэл олон улсын хөтөлбөрөөр сургалт эрхэлдэг ахлах сургууль, МУИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль төгсөгч МУИС-д шинээр элсэн суралцах, МУИС-тай байгуулсан гэрээний дагуу бусад их сургууль, коллежийн оюутан солилцооны хөтөлбөрт суралцаад буцаж ирэх, гэрээнд заасны дагуу МУИС-ийн болон дотоод, гадаадын их сургуулийн зэргийн бус сургалтад суралцах, хичээл солилцооны гэрээний дагуу дотоодын их сургууль, коллежид хичээл судлах, хэд хэдэн хөтөлбөрөөр зэрэгцэн суралцах, сургуулиас чөлөөлөгдсөн суралцагч МУИС-д эргэн суралцах, МУИС-ийн хөтөлбөрийн онцлогоос хамааран хичээл дүйцүүлэх тохиолдолд энэхүү журмыг баримтална.

1.4. Суралцагч гадаадын их сургууль, коллежид суралцах эсвэл гадаадын их сургууль, коллежоос МУИС-д суралцах үед дүнгийн системийг хөрвүүлэх, МУИС-ийн багц цаг болон тухайн сургуулийн багц цагийн харьцааг тодорхойлоход энэхүү журамд тусгагдсан дүн болон багц цагийн хөрвүүлэлтийн аргачлалыг ашиглана.

ХОЁР. Журмын нэр томьёо

2.1. *Хичээл дүйцүүлэх* гэж нэг сургалтын байгууллагад судалсан хичээлийн суралцахуйн үр дүн, багц цаг, үнэлгээг нөгөө сургуулийн харгалзах хичээлийн суралцахуйн үр дүн, багц цагийн агууламж, стандарт болон үнэлгээний системээс хамааруулан дүйцүүлэн тооцох үйл ажиллагааг;

2.2. *Багц цаг хөрвүүлэх* гэж нэг сургалтын байгууллагад судалсан хичээлд ноогдуулсан багц цагийг ачааллаас хамааруулан нөгөөд сургалтын ачааллаас хамааруулан хөрвүүлэн тооцох үйл ажиллагааг;

2.3. *Дүн дүйцүүлэх* гэж нэг сургалтын байгууллагад суралцаж үнэлэгдсэн хичээлийн дүнг нөгөөд, үнэлгээний системээс хамааруулан дүйцүүлэх үйл ажиллагааг;

2.4. *Зэргийн бус сургалт (Micro-Credentials)* гэж хувь хүн, албан байгууллага, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, мэргэшлийн үндэсний шаталсан бүтцэд нийцсэн, шинжлэх ухааны аль нэг салбар, мэргэжлийн чиглэлээр тодорхой мэдлэг, ур чадвар, хандлага олгоход чиглэсэн, үнэлгээний аргачлал, багц цагийн системтэй, хичээлийн индекс, чанарын баталгаа бүхий сургалтыг;

2.5. *Хамтын ажиллагааны гэрээ* гэж гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагууд сургалтын үйл ажиллагаатай холбогдуулан оюутан солилцооны, зэргийн болон зэргийн бус хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх тухай харилцан тохиролцож байгуулсан баримт бичгийг;

2.6. *Хичээл солилцооны гэрээ* гэж хамтын ажиллагааны гэрээ бүхий дотоодын гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагуудын хөтөлбөр хариуцсан профессорын багууд хөтөлбөр/хичээлийн суралцахуйн үр дүн, үнэлгээг харилцан хүлээн зөвшөөрч, сургалтын үйл ажиллагааг аль нэг сургуульдаа судлах боломжийг олгосон, хичээлийн жагсаалт бүхий баримт бичгийг;

2.7. *Суралцах гэрээ (Learning agreement)* гэж хамтын ажиллагааны гэрээнд заагдсан нөхцөлүүдийг хүлээн зөвшөөрч гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж ирэх тухай сургуулийн удирдлага, мэргэжлийн тэнхим болон суралцагчийн хооронд байгуулсан гурвалсан гэрээг;

2.8. *Дэлхийн шилдэг их сургуулийн жагсаалт* гэдэгт дэлхийн их сургууль, коллежуудын эрэмбэ тогтоодог "Times higher education" байгууллагаас гаргасан "impact rankings" шалгуурын сүүлийн оны эрэмбийн жагсаалтыг тус тус хэлнэ.

ГУРАВ. Хичээл дүйцүүлэхэд баримтлах ерөнхий шаардлага

3.1. Хичээл дүйцүүлэх үйл ажиллагаа нь албан ёсны дүнгийн тодорхойлолт болон тухайн хичээлийн хөтөлбөр болох эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлага (суралцахуйн үр дүн)-д үндэслэх ба дараах шалгууруудыг хангасан тохиолдолд дүйцүүлэх боломж нээгдэнэ. Үүнд:

- 3.1.1. Агуулга болон суралцахуйн үр дүнгийн 80-аас багагүй хувийн давхцалтай, цааш үргэлжлүүлэн суралцахад бэрхшээл учруулахааргүй;
- 3.1.2. Дүйцүүлэх хичээл нь МУИС-ийн мэргэжлийн багцын хичээл бол багц цагийн зөрүүгүй байна. Ерөнхий суурь, мэргэжлийн суурийн багцын хичээлийн тухайд 1 багц цагийн зөрүүтэй байж болно. Энэ тохиолдолд өмнө судалсан хичээлийн багц цаг дүйцүүлэх хичээлийн багц цагаас бага байж болохгүй;
- 3.1.3. Үнэлгээ нь тодорхойгүй буюу дүнд хувиргах боломжгүй ("тооцов" гэх мэт дүгнэгдсэн) хичээлийг дүйцүүлэн тооцно;
- 3.1.4. МУИС-ийн харгалзах хичээл нь өмнөх залгамж холбоотой бөгөөд залгамж холбооны өмнөх хичээлүүдийг дүйцүүлэх (судалсанд тооцох)

боломжгүй тохиолдолд уг хичээлийг дүйцүүлэхгүй. Залгамж холбооны өмнөх хичээлийг МУИС-д амжилттай судалсан ч тухайн хичээлийн дүйцүүлэлтийг нөхөж хийхгүй;

- 3.1.5. Төгссөнөөс хойш 10 жил хэтэрсэн бол тухайн хөтөлбөрийн хичээлүүдийг дүйцүүлэхгүй;
- 3.1.6. Ижил түвшний хөтөлбөрүүдэд тусгагдсан байх;
- 3.1.7. МУИС-д зөвхөн харгалзах хөтөлбөрийн, бакалаврын түвшний бол ерөнхий суурийн болон мэргэжлийн суурийн багцын, магистрын түвшин бол ерөнхий суурь болон мэргэжлийн багцын, докторын түвшний бол мэргэжлийн багцын хичээлүүдээс дүйцүүлж болно.

3.2. Хөтөлбөр хооронд шилжин суралцах

- 3.2.1. Бусад дээд боловсролын сургалтын байгууллагаас шилжин суралцах үед 3.1-т заагдсан журмын шаардлагыг хангасан байх ба дотоодын их сургууль, коллежийн хувьд магадлан итгэмжлэл хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар магадлан итгэмжлэгдсэн сургуулийн хичээлийг дүйцүүлнэ.
- 3.2.2. Бусад дээд боловсролын сургалтын байгууллагаас шилжин ирэх үеийн дүнг МУИС-ийн үнэлгээний системд хөрвүүлсний дараа МУИС-ийн харгалзах хичээлийн дүн нь 70-аас доош үнэлгээтэй болсон тохиолдолд дүйцүүлэн тооцохгүй.
- 3.2.3. Бусад дээд боловсролын сургалтын байгууллагаас шилжин суралцагчийн өмнө нь судалсан хичээлүүдээс бакалаврын өдрийн хөтөлбөрт бол 45 хүртэл, магистрын хөтөлбөрт бол 6 хүртэл, докторын хөтөлбөрт бол 9 хүртэл багц цагийн хичээлийг дүйцүүлэн тооцож болно.
- 3.2.4. Дэлхийн шилдэг 500-д эрэмбэлэгдсэн гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагаас шилжин суралцах тохиолдолд журмын 3.1.7-д тусгасан багцын хязгаарлалт, 3.2.2-т тусгасан дүнгийн босгыг мөрдөхгүй бөгөөд бакалаврын хөтөлбөрт бол 60 хүртэлх, магистрын хөтөлбөрт бол 9 хүртэлх, докторын хөтөлбөрт бол 15 хүртэлх багц цагийн хичээлийг дүйцүүлэн тооцож болно.
- 3.2.5. Бусад дээд боловсролын сургалтын байгууллагаас МУИС-ийн хоёрдогч (орой, эчнээ) хэлбэрийн хөтөлбөрт шилжин суралцахад хичээл дүйцүүлэхгүй.
- 3.2.6. Бусад дээд боловсролын сургалтын байгууллагаас шилжин суралцагчийн хичээлийг дүйцүүлэхдээ хөтөлбөр, хичээлийн онцлог, бусад шаардлагаас хамааруулж журмын 3.2.3, 3.2.4-т тусгагдсан багц цагийн хэмжээг мэргэжлийн тэнхимийн шийдвэрээр бууруулж болно.
- 3.2.7. МУИС-ийн хөтөлбөр хооронд шилжих болон суралцах хэлбэрээ солих (өдөр, орой, эчнээ) тохиолдолд журмын 3.1.1-3.1.6 дахь шаардлагыг хангасан хичээлүүдийг дүйцүүлж болох ба журмын 3.1.7-д заасан багцын хязгаарлалтыг мөрдөхгүй.

3.3. Хичээл солилцон суралцах

- 3.3.1. МУИС-тай байгуулсан хичээл солилцон судлах гэрээний дагуу МУИС-ийн суралцагч дотоодын их сургуульд судалж ирсэн хичээлийг шууд тооцож болно.

- 3.3.2. МУИС-тай байгуулсан хичээл солилцооны гэрээний дагуу өөр сургуулийн суралцагч МУИС-д судалсан хичээлээ эргэн МУИС-д тооцуулах тохиолдолд дүйцүүлэлтийг шууд хийх ба энэ нь журмын 3.1.7-д заасан багцын хязгаарлалтад хамаарахгүй. Бакалаврын түвшний хөтөлбөрийн суралцагчийн хувьд 15, ахисан түвшний хөтөлбөрийн суралцагчийн хувьд 6 багц цаг хүртэл дүйцүүлнэ.

3.4. Хамтарсан хөтөлбөрөөр суралцах

- 3.4.1. МУИС нь гадаадын их сургуультай хамтран хэрэгжүүлдэг хамтарсан (joint) болон хос зэрэг олгодог (double degree) зэргийн хөтөлбөрүүдийн дагуу суралцаж ирсэн МУИС-ийн суралцагчийн багц цагийг хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх тухай албан ёсны баримт бичигт заасны дагуу тооцно. Суралцагч эдгээр хөтөлбөрүүдээр суралцахаар явах үед суралцахуйн гэрээнд үзэх хичээл болон түүнийг МУИС-д дүйцүүлэх хичээлүүдийг заавал тусгасан байна.

3.5. Оюутан солилцооны хөтөлбөрийн дагуу судалсан хичээлийг дүйцүүлэх

- 3.5.1. Хамтын ажиллагааны гэрээний дагуу гадаадын их сургуульд зэргийн бус хөтөлбөрт хамрагдан амжилттай дүгнэгдсэн хичээлийг дүнгийн тодорхойлолтод тулгуурлан дүйцүүлнэ.
- 3.5.2. Оюутан солилцооны хөтөлбөрт хамрагдан явах суралцагч нь илгээгч тал болох мэргэжлийн тэнхимтэйгээ хамтран очих сургуульдаа судалж болох хичээл, эргэн МУИС-д ирээд дүйцүүлж болох хичээлийг заавал урьдчилан тодорхойлж, суралцахуйн гэрээнд тусгасан байна. Очих сургуульд үзэх хичээл өөрчлөгдсөн тохиолдолд заавал мэргэжлийн тэнхим, сургалт, хөтөлбөр хариуцсан нэгжид мэдэгдэж суралцахуйн гэрээнд заагдсан судлах хичээлийг шинэчилсэн байна. Суралцахуйн гэрээнд МУИС-д эргэн ирээд дүйцүүлэх хичээл нь төлбөртэй байх эсэх тухай хамтын ажиллагааны гэрээнд үндэслэн заавал тусгасан байна.

3.6. Дараагийн түвшний сургалтад элсэн суралцах

- 3.6.1. МУИС-ийн төгсөгч нь дараагийн түвшний сургалтад элсэн суралцах тохиолдолд магистр, докторын түвшинд зэрэг судлах боломжтойгоор тодорхойлогдон тусгагдсан ижил хичээлүүдийг шууд дүйцүүлэн тооцно.
- 3.6.2. МУИС-аас бусад сургуулийн төгсөгч нь МУИС-ийн дараагийн түвшний хөтөлбөрт элсэн суралцах тохиолдолд хичээл дүйцүүлэхгүй.
- 3.6.3. Дэд бакалаврын зэрэгтэй төгссөн төгсөгч МУИС-д үргэлжлүүлэн суралцах тохиолдолд журмын 3.1.1-3.1.5-д тусгасан шаардлагыг хангасан хичээлийг дүйцүүлж болно.

3.7. Ижил түвшинд шинээр элсэн суралцах

- 3.7.1. МУИС-ийн төгсөгч нь ижил түвшний өөр хөтөлбөрт элсэн суралцах тохиолдолд өмнөх хөтөлбөрийн хичээлээс журмын 3.1.1-3.1.6-д тусгасан шаардлага хангасан хичээлийг дүйцүүлж болох ба журмын 3.1.7-д тусгасан багцын хязгаарлалтыг мөрдөхгүй.

3.7.2. Бусад их сургуулийн төгсөгч нь МУИС-ийн ижил түвшний хөтөлбөрт элсэн суралцах тохиолдолд журмын 3.1.1-3.1.6-д тусгасан шаардлагыг хангасан МУИС-ийн ерөнхий суурийн хичээлийг дүйцүүлж болно.

3.8. Бакалаврын бэлтгэл хөтөлбөрөөс элсэн суралцах

3.8.1. МУИС-ийн хариуцан хэрэгжүүлдэг бэлтгэл хөтөлбөрийн хичээлээс МУИС-ийн бакалаврын үндсэн хөтөлбөрт заагддаг хичээлийн тодорхойлолтын дагуу заагдсан хичээлийг МУИС-д элсэн суралцсан тохиолдолд дүйцүүлнэ.

3.9. Иргэн статусаар суралцаад МУИС-д элсэн суралцах

3.9.1. МУИС-д “иргэн” статусаар суралцсан суралцагч үндсэн суралцагчаар элсэн суралцах тохиолдолд МУИС-ийн зэргийн хөтөлбөрт заагддаг хичээлийн тодорхойлолтын дагуу заагдсан, журмын 3.1.1-3.1.5-д тусгасан шаардлагыг хангах хичээлүүдээс бакалаврын хөтөлбөрт бол 30 хүртэлх, магистрын хөтөлбөрт бол 6 хүртэлх, докторын хөтөлбөрт бол 9 хүртэлх багц цагийн хичээлийг шууд тооцно.

3.10. МУИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулиас элсэн суралцах

3.10.1. МУИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуульд МУИС-ийн бакалаврын үндсэн хөтөлбөрт заагддаг хичээлийн тодорхойлолтын дагуу заагдсан хичээлийг МУИС-д элсэн суралцсан тохиолдолд дүйцүүлнэ.

3.11. Эргэн суралцах

3.11.1. Өмнө нь МУИС-д суралцаж байсан (захирлын тушаалаар чөлөөлөгдсөн) суралцагч нь чөлөөлөх тушаал гарснаас хойш 10 жилийн дотор суралцагч элсүүлэх журмын дагуу эргэн суралцах тохиолдолд журмын 3.1.1-3.1.6-д тусгасан шаардлагыг хангасан хичээлийг дүйцүүлж болно.

3.11.2. Бусад их сургуульд суралцаж байсан суралцагч МУИС-д суралцагч элсүүлэх журмын дагуу элсэн суралцах тохиолдолд өмнө нь судалсан хичээлийг дүйцүүлэхгүй.

3.12. Зэрэгцэн (хос) сургалтын үед хичээл дүйцүүлэх

3.12.1. МУИС дотроо ижил түвшний хөтөлбөрт зэрэгцэн суралцаж буй тохиолдолд журмын 3.1.1-3.1.6-д заасан шаардлагыг хангасан хичээлүүдийг дүйцүүлнэ.


3.12.2. МУИС-тай хичээл солилцооны гэрээ байгуулсан их сургууль болон МУИС-д зэрэг суралцаж буй суралцагчийн журмын 3.1.1-3.1.6 хүртэлх шаардлагыг хангасан бакалаврын бол 15, ахисан түвшний бол 6 хүртэлх багц цагийн хичээлийг дүйцүүлэн тооцож болно.

3.12.3. Ижил түвшний хөтөлбөрт зэрэгцэн суралцаж буй тохиолдолд бакалаврын хөтөлбөрийн чөлөөт сонголт, магистр докторын бусад, тэнхим, салбар нэгжийн судлах багцын гүйцэтгэлийг зэрэгцэн суралцаж буй нөгөө хөтөлбөрийн хичээлээр дүйцүүлж болно.

3.13. Зэргийн бус сургалтын үед хичээл дүйцүүлэх

3.13.1. Зэргийн бус сургалтын хөтөлбөрийн хичээлийг журмын 3.1.1-3.1.6-д тусгасан шаардлагын дагуу Сургалт, хөтөлбөр хариуцсан нэгж дүйцүүлнэ.

3.13.2. Зэргийн бус сургалтын хөтөлбөр, гэрээнд хичээл дүйцүүлэх нөхцөлийг тусгасан байна.



3.14. Олон улсын шалгалтад авсан үнэлгээг дүйцүүлэх

3.14.1. Монгол улсад албан ёсоор Кембрижийн болон олон улсын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж буй дунд сургуульд эсвэл гадаадын ижил түвшний сургуульд судалж олон улсын А, О түвшний шалгалтад С ба түүнээс дээш үнэлгээ авсан, AS, IB, AP IGCSE түвшний шалгалтад А үнэлгээ авсан бол бакалаврын хөтөлбөрийн ерөнхий суурийн ижил чиглэлийн хичээлүүдтэй дүйцүүлэн тооцож болно.

3.14.2. Шалгалтын агуулгаас хамаарч А, О түвшний шалгалтын хувьд 6 хүртэлх, AS, IB, AP IGCSE түвшний шалгалтын хувьд 3 хүртэлх багц цагийг дүйцүүлнэ.

3.14.3. Дүйцүүлэлт хийхэд тухайн сургуулийн Кембрижийн олон улсын сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл болон дүнгийн албан ёсны тодорхойлолтыг хавсаргасан байна.

3.14.4. А түвшний шалгалтын оноогоор дүйцүүлэлт хийж байгаа тохиолдолд ижил чиглэлийн AS түвшний шалгалтын оноогоор дүйцүүлэлт хийхгүй.

3.14.5. Уг шалгалтын оноогоор МУИС-ийн ерөнхий суурьт тусгагдсан гүнзгийрүүлсэн түвшний хичээлийг дүйцүүлэхгүй.

ДӨРӨВ. Багц цаг шилжүүлэн тооцох аргачлал

4.1. Багц цагийн тодорхойлолт нь МУИС-тай ижлээр тодорхойлогдсон хичээлийн багц цагийг тэр хэвээр нь ашиглах бөгөөд багц цагийг МУИС-аас өөрөөр тодорхойлсон гадаадын их сургууль, коллежид судалсан хичээлийг МУИС-д тооцохдоо тухайн сургуулийн сургалтын цагийн тухай албан ёсны тайлбар заавал шаардана. Энэ тохиолдолд тухайн багц цагийн тодорхойлолт дахь суралцагчийн ачааллыг МУИС-ийн багц цагийн харгалзах үзүүлэлтүүдэд шилжүүлэн тооцно.

4.2. Гадаадын их сургуулиудад түгээмэл хэрэглэгддэг ялгаатай багц цагийг Хүснэгт 1-д заасны дагуу шилжүүлэн тооцно.

4.3. Журмын 3.1.2-т тусгасан нөхцөлөөс бусдаар МУИС-д дүйцэх хичээлийн багц цагт хүрэхгүй бол шилжүүлэн тооцохгүй. Багц цагийн дутууг харгалзах цагийн хэмжээгээр нэмж судлах мэтээр нөхөн гүйцээхгүй.

4.4. Бусад дээд боловсролын сургалтын байгууллагаас хичээл дүйцүүлэхэд МУИС-ийн дүйцэх хичээлийн, МУИС дотроо бол анхны дүйцэгдэх хичээлийн нэр, багц цагаар хөтөлбөрийн биелэлтэд тооцно.

4.5. Суралцагчийн судалсан хэд хэдэн хичээлийн багц цаг болон агуулга, суралцахуйн үр дүн нь нийлээд МУИС-ийн харгалзах хичээлийн багц цаг, агуулга, суралцахуйн үр дүнгийн шаардлагыг хангаж байвал тухайн хичээлүүдийг нэгтгэн дүйцүүлж болно.

4.6. Суралцагчийн судалсан нэг хичээл нь МУИС-ийн хэд хэдэн хичээлийн агуулга, суралцахуйн үр дүн, багц цагийн шаардлагыг хангасан бол тэдгээр хичээлүүдийг тус тусад нь дүйцүүлж болно.

ТАВ. Суралцагчийн үнэлгээ (дүн)-г дүйцүүлэх аргачлал

5.1. Бусад дээд боловсролын сургалтын байгууллагуудад түгээмэл хэрэглэгддэг үнэлгээний системийг Хүснэгт 2-т заасны дагуу МУИС-д хөрвүүлэн тооцно.

5.2. Суралцагчийн хичээлийн үнэлгээ нь МУИС-ийн үнэлгээний системээс (дүнгийн шатлал) өөр бол тухайн сургуулийн дүнгийн шатлалын тухай албан ёсны тайлбарыг шаардах бөгөөд хэрэв боломжгүй бол амжилттай дүнг 60-95 онооны завсарт жигд харгалзуулах замаар шилжүүлэн тооцно. Тухайлбал, тухайн сургууль оюутны мэдлэгийг онц, сайн, дунд, муу гэж үнэлдэг бол 60-71, 72-83, 84-95 оноог амжилттай дүнд харгалзуулан дунд -66, сайн -78, онц -90 гэж оноох юм уу, эсвэл үнэлгээг тооцсон багц цагийн нарийвчлалтай холбож багц цагийг бууруулан тооцсон бол интервалын дээд оноог харгалзуулж болно.

5.3. МУИС-д дүйцүүлэн тооцох дүн нь МУИС-ийн үнэлгээний системийн аль нэг интервалаар тодорхойлогдож байвал уг интервалын дундаж утгаар эцсийн үнэлгээг тогтооно.

5.4. Дүн дүйцүүлэхдээ тухайн хичээлээр дүгнэгдсэн нийт суралцагчдын сүүлийн 2-3 жилийн дүнгийн тархалтад үндэслэн тооцоолж болно. Ийм тохиолдолд тухайн хичээлийн дүн нь дүнгийн тархалтын дээд 10%-д хамаарагдаж байвал А дүнтэй, дараагийн 25%-д харгалзаж байвал В, дараагийн 30% нь С, дараагийн 25% нь D, харин сүүлийн 10%-д харгалзаж байвал F үнэлгээ тавина.

5.5. Журмын 4.4-т заасны дагуу хэд хэдэн хичээлийг нэгтгэн дүйцүүлж байгаа тохиолдолд үнэлгээг тухайн хичээлүүдийн багц цаг ба дүнгийн жигнэсэн дунджаар тооцоолох ба бутархай дүнг ойролцоолж бүхэл болгоно.

$$D = \frac{\sum_{i=1}^n K_i \cdot D_i}{\sum_{i=1}^n K_i}$$

n - дүйцүүлэх хичээлийн тоо

K_i - тухайн (i) дугаар дүйцүүлэх хичээлийн багц цаг

D_i - тухайн (i) дугаар дүйцүүлэх хичээлийн дүн

D – дүйцэх дүн

5.6. Журмын 4.5-д заасны дагуу нэг хичээлээр МУИС-ийн хэд хэдэн хичээлийг дүйцүүлж байгаа тохиолдолд МУИС-ийн хичээл бүрийн үнэлгээ нь дүйцүүлэх хичээлийн үнэлгээтэй адилхан байна.

5.7. Олон улсын шалгалтын А түвшний А үнэлгээг 95, В үнэлгээг 85, С үнэлгээг 75; AS түвшний А үнэлгээг 85 оноогоор тооцно.

5.8. МУИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуульд амжилттай судалж журмын 3.10-т заасан шаардлагыг хангасан хичээлийн дүнг тэр хэвээр нь тооцно.

5.9. Үнэлгээ нь тодорхойгүй буюу дүнд хувиргах боломжгүй "тооцов" хичээлийг дүйцүүлэн тооцохдоо тухайн боловсролын байгууллагын үнэлгээний системд үндэслэн Сургалт, хөтөлбөр хариуцсан нэгж үнэлгээг тодорхойлно.

5.10. МУИС-аас өөр сургуульд судалсан хичээлийг МУИС-д дүйцүүлэн тооцох тохиолдолд үсгэн үнэлгээг CR (credit granted) тэмдэглээгээр оруулна.

ЗУРГАА. Хэлний шалгалтын оноог дүйцүүлэх

6.1. Мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлийн бүлэгтээ гадаад хэл судлуулахаар тусгасан бакалаврын сургалтын хөтөлбөрийн анхан шатны хэлний хичээлүүдийг харгалзах хэлний олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шалгалтын оноогоор дүйцүүлэн тооцуулж болох боловч шалгалтын оноо нь тухайн шалгалтаар авч болох хамгийн их онооны 60 хувиас багагүй байх тохиолдолд дүйцүүлэх боломж нээгдэнэ. Дүйцүүлэлт хийх үед тухайн шалгалтыг өгсөн тухай албан ёсны сертификатыг хавсаргана.

6.2. Дүйцүүлж болох олон улсын шалгалтын нэр, түвшин тогтоосон сертификатын хүчинтэй хугацаа болон дүйцүүлж болох хичээлийн нэр, багц цагийг мэргэжлийн тэнхим хэлэлцэж шийдвэрлэнэ.

6.3. МУИС-ийн бакалаврын түвшний суралцагчид тавигдах гадаад хэлний ерөнхий шаардлагыг тухайн хэлний олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шалгалтын оноогоор хангасанд тооцож болох ба 6.3-д заагдсанаас бусад тохиолдолд олон улсын шалгалтын оноогоор МУИС-ийн хичээл дүйцүүлэхгүй.

6.4. Гадаад хэлний шалгалтын сертификатын оноогоор МУИС-ийн ахисан түвшний хөтөлбөрийн хичээл дүйцүүлэхгүй.

Долоо. Хичээл дүйцүүлэх үйл ажиллагаа

7.1. МУИС-ийн хичээл дүйцүүлэлтийн үйл ажиллагааг Сургалт, хөтөлбөр хариуцсан нэгж суралцагч, мэргэжлийн тэнхимтэй хамтран зохион байгуулна.

7.2. Суралцагч хичээл дүйцүүлэх тухай өргөдлийг маягтын дагуу (Маягт 1) холбогдох материалуудын хамт Сургалт, хөтөлбөр хариуцсан нэгжид гаргах ба өргөдлийг хянан үзэж, журмын шаардлага хангасан тохиолдолд хичээл дүйцүүлэлтийн маягтыг (Маягт 2) бөглөж харьяа тэнхимд хандана.

7.3. МУИС-д дүйцүүлж буй хичээл нь МУИС-ийн хичээл дүйцүүлэлтэд баримтлах зарчим болон харгалзах хичээлтэй агуулгаараа давхцаж байгаа эсэх (журмын 3-р бүлэг), багц цагийн хэмжээ нь шаардлага (журмын 4-р бүлэг) хангаж буй эсэх талаар тухайн хичээлийг хариуцан заадаг мэргэжлийн тэнхим (тэнхимийн эрхлэгч эсвэл тухайн хичээлийг заадаг багш)-ийн дүгнэлт/зөвшөөрлийг заавал авсан байх ба харгалзах тэнхимийн эрхлэгч нь баталгаажуулсан байна.

7.4. Журмын 7.3-д заасан мэргэжлийн тэнхимийн зөвшөөрөл бүхий дүйцүүлж болох хичээлийн дүнгийн дүйцүүлэлтийг энэхүү журмын 5-р бүлэгт заасан аргачлалын дагуу Сургалт, хөтөлбөр хариуцсан нэгж хийнэ.

7.5. Хичээл дүйцүүлэлтийн бөглөгдсөн маягтыг суралцагчийн зөвшөөрөл болон Сургалт, хөтөлбөр хариуцсан нэгжийн даргын баталгаажуулалтад үндэслэн бүртгэл, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн системд оруулна.

7.6. Зэргийн бус хөтөлбөрт хамрагдаад ирсэн суралцагчийн хичээлийг ирсэн улиралд нь дүйцүүлж оруулна.

НАЙМ. Бусад


8.1. Хичээл дүйцүүлэлтийн үйл ажиллагааг элссэн, шилжсэн, эргэн суралцсан тухайн улиралд суралцагчийн хүсэлтээр нэг удаа хийнэ.

8.2. Хичээл дүйцүүлэлтийг аргачлалын дагуу зөв хийгээгүй тохиолдолд дүйцүүлэлтийг буцааж, дахин засварлаж оруулна.

8.3. Оюутан солилцооны болон бусад гэрээнд тусгайлан заагаагүй бол МУИС-д хичээл дүйцүүлэхэд төлбөр авахгүй.

8.4. МУИС-ийн хичээл дүйцүүлэх тухай гэрээ байгуулсан гэрээний дагуу судалсан ахлах сургууль, дээд боловсролын сургалтын байгууллага, бусад байгууллагад судалсан хичээлийг гэрээний дагуу тооцно.

8.5. Энэхүү журмаар зохицуулагдаагүй асуудлыг МУИС-ийн ректорын зөвлөл хэлэлцэж шийдвэрлэнэ.



Хүснэгт 1

Түгээмэл хэрэглэгддэг багц цаг болон МУИС-ийн багц цагийн харьцааны
хүснэгт

Монгол	ECTS	АНУ*	БНХАУ	Энэтхэг	Япон	БНСУ	ОХУ**	Австрали	Канад	Сингапур
1 багц цаг	2	1	1	1	1	1	2	2	ATA13089 0.17	9104399 1.6

* Улирлын багц цагт суурилсан кредит системтэй сургууль бол багц цагийг 3/2 коэффициентэд хувааж тооцно.

** Багц цагаар хэмжигддэггүй, танхимын цагаар тодорхойлогддог сургалтын системтэй бол 72 танхимын цагийг 1 багц цаг гэж үзнэ.

Хүснэгт 2-А

Ялгаатай дүнгийн шатлалыг МУИС-ийн дүнгийн шатлалд хөрвүүлэх хүснэгт


Монгол Улсын Их Сургууль	Хувилбар 1	Хувилбар 2	Хувилбар 3	Хувилбар 4
95-100	96-100	98-100 94-97	96.0-100.0	90-100
90-94	91-95 88-90	91-93 88-90	90.0-95.9 87.0-89.9	80-89
85-89	84-87	84-87	83.0-86.9	70-79
80-84	81-83	81-83	80.0-82.9	60-69
75-79	78-80	78-80	77.0-79.9	50-59
70-74	74-77 71-73	74-77 71-73	73.0-76.9 70.0-72.9	40-49
65-69	68-70 64-67	68-70 64-67	67.0-69.9 63.0-66.9	30-39
60-64	60-63	60-63	60.0-62.9	20-29
0-59	0-60	31-60 0-30	0-59.9	0-60

Хүснэгт 2-Б

Гадаадын түгээмэл хэрэглэгддэг үнэлгээний системийг МУИС-ийн үнэлгээний системд хөрвүүлэх хүснэгт

Монгол	A+	A	A	A-	B+	B	B	B-	C+	C	C	C-	D+	D	D	D-	F	F	F
	100	95	95	90	89	85	85	80	79	75	75	70	69	65	65	60	59	59	F
ECTS	A	A	A	A	B	B	B	B	C	C	C	C	D	D	E	E	F	F	F
Хятад	Exc	Exc	Exc	Exc	Vgood	Vgood	Vgood	Vgood	Good	Good	Good	Good	Satis	Satis	Pass	Pass	Fail	Fail	Fail
	100	95	95	90	89	85	85	85	80	79	75	75	70	69	65	60	59	59	59
Тайвань	100	95	90	80	79	75	75	70	69	65	65	60							
	100	95	95	90	87	84	83	80	79	75	75	70	65	60	55	50	49	59	59
Орос	5	5	5	5	5	4	4	4	3	3	3	3	3	3	3	3	2		
	excellent	excellent	excellent	excellent	excellent	excellent	good	good	satisfactory	satisfactory	satisfactory	satisfactory	satisfactory	satisfactory	Pass	Pass	Fail	Fail	Fail
Япон	S/A+ 100	S/A+ 95	S/A+ 95	S/A+ 90	A 89	A 89	A 85	A 85	A 80	B 75	B 75	B 75	B 70	C 69	C 65	C 60	F/D 40-59	F/D 40-59	F/E <40
Англи, Ирланд	85,A 1	80,A 2	73,A 3	70,A 4	67, B+ 5	65,B+ 6	63, B+ 7	60,B+ 8	57,B 9	55,B 10	53,B 11	50,B 12	47,C+ 13	45,C+ 14	43,C 15	40,C 16	35,D 17	30,D 18	<30,E,F 19
Итали	30	30	30	30	29	27	25	23	22	21	21	20	19	18	18	17	16	15	<15
Бельги, Франц	20	20	19	19	18	18	17	17	16	16	15	14	13	12	11	10	9	8	<8
Португаль	20	19	18	17	16	15	14	14	13	13	12	12	11	11	10	10	9	7	<5
Дани	12	12	12	12	10	10	10	10	7	7	7	7	4	4	2	2	0	0	0
Голланд	10	9	9	9	8	8	7	7	6	6	6	6	5.5	5.5	5	5	4	3	<3
Литви	10	10	9	9	8	8	8	8	7	7	6	6	5	5	5	5	4	3	2
Испани, Румын	10	10	9	9	8	8	8	7	7	7	6	6	5	5	5	5	4	3	2,1
Исланд	10	10	9	9	8	7	7	7	6	6	6	6	5	5	5	5	4	4	3,2,1
Грек, Кипр	10	10	9	9	8	8	8	8	7	7	6	6	5	5	4	4	3	2,1	0
Швейцарь	6	5.75	5.5	5.25	5	5	4.75	4.75	4.5	4.5	4.5	4.5	4.25	4.25	4	4	<4	<4	<4
Болгарь	6	6	6	6	5	5	5	5	4	4	4	4	3	3	3	3	2	2	2
Польш(2)	5	5	5	5	4+	4+	4+	4+	4	4	4	4	3+	3+	3	3	2	2	2
Унгар, Швед, Хорват	5	5	5	5	4	4	4	4	3	3	3	3	2	2	2	2	1	1	1
Финланд(1)	3	3	2.5	2.5	2	2	2	2	1.5	1.5	1.5	1.5	1	1	1	1	0	0	0
MU	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19
Норвеги	1.6	1.7	1.8	1.9	2	2.1	2.3	2.5	2.6	2.7	2.8	2.9	3	3.3	3.5	4	4.1	4.5	5
Герман	1	1	1	1	2	2	2	2	3	3	3	3	4	4	4	4	5	5	6

Австри	1	1	1	1	1	2	2	2	2	3	3	3	4	4	4	4	5	5	5
Чех	1	1	1	1	1	2	2	2	2	2	2	3	3	3	3	3	4	4	4
Эстони	A	A	A	A	A	B	B	B	B	C	C	C	D	D	E	E	F	F	F
Мальт	A+	A	A	A	A	B+	B	B	B	C+	C	C	D+	D	D	F	F	F	F
Өмнөд солонгос	A+	A	A	A	A	B+	B	B	B	D+	D	D				F	F	F	F
Турк	AA	AA	AA	AA	AA	BA	BA	BA	BA	BB	BB	CB	CC	CC	DD	F	F	F	F
Хонгконг, Энэтхэг	A	A	A	A	A	B	B	B	B	C	C	C	D	D	D	F	F	F	F
Словак	Exc A	Exc A	Exc A	Exc A	Exc A	Vgood	Vgood	Vgood	Vgood	Good	Good	Good	Satis	Satis	Pass	Fail	Fail	Fail	Fail
Словани	Exc A	Exc A	Exc A	Exc A	Exc A	Vgood	Vgood	Vgood	Vgood	Good	Good	Good	Satis	Satis	Pass	Fail	Fail	Fail	Fail
Сингапур	Class I	Class I	Class I	Class I	Class I	Class II	Class II	Class II	Class II	Class III	Class III	Class III	Class III	Class III	Class III	Class III	Class III	Class III	Class III
Америк	100	95	95	90	89	85	85	85	8	79	75	75	69	65	60	59			
Австрали	7	7	7	7	7	7	7	7	7	6	6	6	5	5	4	3	3	3	3
Малайз	100	95	95	90	89	85	85	85	80	79	75	75	69	65	60	59			



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ХИЧЭЭЛ ДҮЙЦҮҮЛЭХ ТУХАЙ ӨРГӨДӨЛ

- Хичээл дүйцүүлэлт хийхийн өмнө “МУИС-д хичээл дүйцүүлэх журам”-тай сайтар танилцана уу.
- Хэрэв та өөр их сургуулийн хичээлийг МУИС-д дүйцүүлэн тооцуулахыг хүсэж байгаа бол тухайн сургуулиас албан ёсны дүнгийн тодорхойлолт болон хичээл бүрийн суралцахуйн үр дүнгийн (хичээлийн хөтөлбөр) мэдээллийг Маягт 2-т бөглөх эсвэл хавсаргасан байхыг анхаарна уу.
- МУИС-ийн суралцагч гадаадын их сургуульд суралцахуйн гэрээгээр суралцаад ирсэн бол холбогдох хамтын ажиллагааны болон суралцахуйн гэрээ зэргийг хавсаргана уу.
- Хичээл дүйцүүлэлтийн үйл ажиллагаа нь нэг л удаа явагдахыг анхаарна уу.
- Энэхүү өргөдлийг харьяа бүрэлдэхүүн сургуулийн бүртгэл, үнэлгээ хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгнө үү.

Суралцагчийн мэдээлэл

☐ Эр. ☐ Эм.

Ургийн овог _____ Эцэг/эхийн нэр _____ Нэр _____

Регистрийн дугаар: _____ Суралцагчийн дугаар: _____

Холбоо барих утас: _____ И-мэйл хаяг: _____

Хичээл дүйцүүлэлтийн шалтгаан (дугуйлна уу) *:

1. МУИС-ийн хөтөлбөрт шилжин суралцаж буй
 - Өмнө нь суралцаж байсан сургууль, хөтөлбөрийн нэр: _____
2. МУИС-ийн хөтөлбөрт элсэн суралцаж буй
 - МУИС-ийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулиас
 - Кембрижийн сургалт бүхий сургуулиас
 - Өгсөн шалгалтын түвшин (дугуйлна уу): “А” “О” “AS” “IB” “AP” “IGCSE”
 - Эргэн суралцах: _____/чөлөөлөгдсөн огноо/
 - Өмнө нь дээд боловсрол эзэмшсэн

Сургууль, хөтөлбөрийн нэр, боловсролын зэрэг, төгссөн огноог бичнэ үү.

3. Зэргийн бус сургалтад хамрагдаад ирсэн
4. Зэргийн сургалтад хамрагдаад ирсэн
5. Оюутан солилцоо
6. Хичээл солилцооны гэрээний дагуу дотоодын их сургуульд хичээл судалсан

3-5-р сонголтыг сонгосон бол ямар тэнхим, сургуулийн гэрээний дагуу аль их сургуулийн хөтөлбөрт хамрагдаад ирснийг бичнэ үү.

7. МУИС-ийн хөтөлбөрийн өөрчлөлт
- Бусад _____

Дүйцүүлэх хичээлийн багц цагийн төлбөр төлөх эсэх (дугуйлна уу): “Тийм” “Үгүй”

* Хичээл дүйцүүлэх болсон үндсэн шалтгааныг заавал дугуйлна уу. Энэхүү өргөдлийн маягтад нэмэлтээр дэлгэрэнгүй өргөдлийг бичин хавсаргаж болно.

Өргөдөл гаргасан: _____ Огноо: _____

(нэр, гарын үсэг)

Өргөдлийг хүлээн авсан: _____ Огноо: _____

(Бүртгэл, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн)

		МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ	
		ХИЧЭЭЛ ДҮЙЦҮҮЛЭЛТИЙН ХҮСНЭГТ	
		Маягт 2.	
		 ОНЫ ...-р сарын ... өдөр	
Суралцагчийн овог нэр:		Суралцагчийн дугаар (ID):	
МУИС-ийн суралцах хөтөлбөр:			
Тайлбар:			
Зэргийн болон зэргийн бус хөтөлбөр:			
МУИС-д шинээр элсэгч:			
Өөр сургуулиас шилжин ирж буй		(Өмнөх сургууль, хөтөлбөрийн нэр):	
МУИС-ийн хөтөлбөр хооронд шилжиж буй		(Өмнө нь суралцаж байсан хөтөлбөр):	
Хоёрдогч бакалавр		(Өмнөх хөтөлбөрийн нэр):	
Бусад:			

Хичээлийн агуулга, суралцахуйн үр дүнгийн нийцтэй байдал:

№		Өмнө нь судалсан хичээлийн	МУИС-ийн дүйцүүлэн тооцох хичээлийн***	Нийцлийн хувь****
1	Нэр			
	Агуулга, суралцахуйн үр дүн*			
	Баталгаажуулалт**			
2	Нэр			
	Агуулга, суралцахуйн үр дүн*			
	Баталгаажуулалт**			
3	Нэр			
	Агуулга, суралцахуйн үр дүн*			
	Баталгаажуулалт**			

* Дүйцэх, дүйцэгдэх хичээлийн агуулга, сэдэвчилсэн төлөөлөгөө, суралцахуйн үр дүнгийн мэдээллийг бичнэ.
** Өмнө нь судалсан хичээлийн харьяа нэгжийн зүгээс хичээлийн агуулга, суралцахуйн үр дүнгийн мэдээллийг баталгаажуулсан байна. Албан ёсны гарын үсэг, тамга бүхий хичээлийн мэдээлэл тусад нь хаасараах бол баталгаажуулалтын гарын үсэг шаардахгүй.
*** МУИС-ийн дүйцүүлэн тооцох хичээлийн мэдээллийг сургалтын мэдээллийн системээс бөглөж болно.
**** Нийцлийн хувийг уг хичээлийг заадаг МУИС-ийн багш тодорхойлж, баталгаажуулалтын гарын үсэг зурна.

